



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.05 № ГНАГ-2024/13-МТА-НА-11

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**САНТ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛ АРДЫН  
НАМД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Монгол Ардын намын Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


Сант сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр ( 5 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сант сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНТ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

**САНТ СУМ  
2024 ОН**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС  
ДЭВШҮҮЛЖ БҮЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024.06.24

**САНТ САЙХАН НУТГАА  
“ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ”**




**Монгол Улсын хөгжлийн “Алсын хараа-2050”-ийг үндсэн чиглэл болгон Монгол Ардын Намаас УИХ-ын 2024 оны сонгуульд дэвшүүлсэн хөгжлийн зорилтуудыг орон нутагтаа хэрэгжүүлэх, Сант нутгийнхаа хөгжлийг шинэ шатанд гаргах зорилгоор сум, орон нутгийнхаа ард иргэд, аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагуудаас мөрийн хөтөлбөрт тусгуулахаар ирүүлсэн саналуудыг нягтлан үзэж, нэгтгэн дүгнэж, сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өнөөгийн байдалд тулгуурлан Сант сумын Монгол Ардын Намын Хорооноос 2024-2028 онд сумын хөгжил, дэвшил, хүн ардынхаа сайн сайхны төлөө хийж, хэрэгжүүлэх ажлаа хураангуйлан тусгасан мөрийн хөтөлбөрөө сонгогч олондоо өргөн барьж байна.**

**НЭГ. ЭРҮҮЛ МЭНД**

- 1.1. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн, иргэдийн санал санаачлагаар байгуулагдсан дасгал хөдөлгөөн, биеийн тамирын клуб, бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.
- 1.2. Сумын эрүүл мэндийн төвийг орчин үеийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг холбогдох байгууллагуудад уламжлан, шийдвэрлүүлнэ.
- 1.3. Нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтаны тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрахад анхаарч, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.4. Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт иргэдийг бүрэн, тэгш хамруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.5. Туулах чадвар сайтай түргэн тусламжийн авто машинаар хангагдах ажлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.
- 1.6. Уламжлалт анагаах ухааны эмчилгээний кабинет, бариа засал, эмийн сангийн өрөө зэргийг стандартад нийцүүлэн тохижуулах боломжийг судалж, хэрэгжүүлнэ.
- 1.7. Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй болгож, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 1.8. Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн үзлэгийг тогтмол зохион байгуулж, эрт илрүүлэх, эрүүлжүүлэх ажлыг сайжруулна.

**ХОЁР. БОЛОВСРОЛ**

- 2.1. Сургууль, цэцэрлэгт жил бүр 1 анги танхимийг тохижуулах ажлыг иргэд, аж ахуйн нэгж болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шийдвэрлэн хэрэгжүүлнэ.

- 
- 2.2. Бага, дунд боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
  - 2.3. Монголын түүх, хэл соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хүүхдийн хөгжил төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг тусган хэрэгжүүлэх, хүүхдийн өөрийнх нь авъяаст тулгуурлан хөгжүүлэх, амьдралын зөв дадалд сургахад дээд шатны байгууллагаас гаргасан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
  - 2.4. Цэцэрлэг, сургуулийн орчинг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчин нөхцлийг бүрдүүлнэ.
  - 2.5. Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолны стандартыг хэрэгжүүлж, сүү сүүн бүтээгдэхүүнээр найдвартай, тогтмол хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
  - 2.6. Цэцэрлэг, сургуульд түшиглэж хүүхэд хамгааллын байрыг бий болгож, тохижуулна.
  - 2.7. Нийгмийн хариуцлагын хүрээнд иргэд, аж ахуйн нэгжийн дэмжлэг, оролцоотойгоор багш, суралцагчдын нийгмийн асуудлыг сайжруулна.
  - 2.8. Хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр барих ажлын зураг төсвийг хийлгэж, улсын төсөвт суулгах ажлыг зохион байгуулна.
  - 2.9. Цэцэрлэг, сургуулийн тусгай хэрэгцээт хүүхдүүдийг сурч боловсрох, хөгжих нөхцөл боломжийг бий болгоно.

#### ГУРАВ. СОЁЛ УРЛАГ

- 3.1. “Монгол хүн-Монгол ахуй, Монгол соёл-Монгол урлаг” бодлогыг хэрэгжүүлж түгээн дэлгэрүүлэхэд соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлнэ.
- 3.2. Соёлын төвийн барилгыг шинээр барих зураг төслийг боловсруулж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлнэ.
- 3.3. “Соёлын бүтээлч үйлдвэрлэл III” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.
- 3.4. Ивэн голын үерийн далан болон хиймэл нуур орчимд аялал жуулчлал, загасчлал, амралт сувилалын чиглэлээр хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.
- 3.5. Сумын номын сан, орон нутаг судлах танхимын үйл ажиллагааг өргөтгөж, үзмэр, сан хөмрөгийг баяжуулж, үйлчилгээ, сурталчилгааны чанарыг дээшлүүлнэ.
- 3.6. Соёлын биет бус өв, язгуур урлагийн сургалтыг бий болгосон хамт олон, өвлөн уламжлагчдыг дэмжиж ажиллана.

#### ДӨРӨВ. ДЭД БҮТЭЦ

- 4.1. Сумын дулааны далд шугам сүлжээг шинэчлэх, засварлах ажлыг үргэлжлүүлж, улмаар сургууль, хүн эмнэлэг, Будлан хорооллын айл өрхүүдийн дулаан, цэвэр бохирын шугамыг уурын зуух болон нэгдсэн шугамд холбох ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.
- 4.2. Сумын төвийн хороолол тус бүрийн гудамжны эмх цэгцийг сайжруулж, гэрэлтүүлгийг бүрэн шийдвэрлэнэ.
- 4.3. Шинэ суурьшлын бүсүүд болон Будлан хороолол, жимсний хашааны зүүн талын айл өрхүүдэд төвлөрсөн 0.4кВт цахилгаан эрчим хүчний шугам татах ажлыг аж ахуйн нэгж, орон нутгийн хөгжлийн санд тусгуулж, шийдвэрлэнэ.

- 4.4. Алслагдсан суурин болон хөдөөд үүрэн телефоны сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 4.5. Зуслан чиглэлийн эвдэрсэн зам, даваа гүвээнд шаардлагатай засваруудыг үе шаттайгаар хийж, гүйцэтгэнэ.
- 4.6. Иргэдийг орон сууцжуулах бүхий л боломжийг эрэлхийлж, хорооллын өрхүүдийг дулаан, цэвэр, бохир усны шугамд холбох ажлыг үргэлжлүүлэн, иргэд тав тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлнэ.
- 4.7. Сумын төвийн гудамж талбайг засварлан сайжруулах ажлыг үргэлжлүүлж, ЗДТГ-аас цэцэрлэг, ЕБС-ийн өмнөх зам талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн баруун талаарх шороон замуудыг тус тус хатуу хучилттай замаар холбох ажлыг замын сан болон орон нутгийн хөгжлийн санд тусгуулж, хэрэгжүүлнэ.

#### ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 5.1. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрт малчдыг хамруулах ажлыг эрчимжүүлж, малчид хоршоолох замаар сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс шир боловсруулах цех байгуулахыг дэмжиж ажиллана.
- 5.2. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх иргэдийн санал, санаачилгыг бүхий л талаар дэмжиж, үхэр сүргийг эрчимжүүлэх герефорд үүлдрийн хээлтүүлэгчээр хангах ажлыг үргэлжлүүлж, шилмэл хуц ухнаар сүргийг сэлбэх ажлыг эхлүүлнэ.
- 5.3. Малчдад тэжээлийн ургамал тариалах нөхцөл боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэнэ.
- 5.4. Хүлэмж, зоорины аж ахуй эрхлэх иргэдийн хүсэл санаачилгыг дэмжиж суманд механикжсан 1000 тн багтаамжтай зоорь барих ажлыг холбогдох байгууллагад уламжилж, улсын төсөвт суулгах тал дээр санал, санаачилга гаргаж ажиллана.
- 5.5. Дөрвөн улирлын хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногоо, жимс жимсгэний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж, жилийн турш шинэ ургацын ногооны хангамжийг сайжруулана.
- 5.6. Алслагдсан бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлнэ.
- 5.7. Тариалангийн хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, хөрс бордох, үр ашигтай технологийг нэвтрүүлэх, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.
- 5.8. Хогийн менежментийг өрх бүрд хэвшүүлж, эзэмшүүлснээр соёлч сум болох эхлэлийг тавьж хэрэгжүүлнэ.
- 5.9. “Шарилж, хогийн ургамал устгах, хадах ажлыг орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвөөр үргэлжлүүлнэ.
- 5.10. Өрх бүр хашаандаа гоёлын мод, жимс, жимсгэнэ, төмс, хүнсний ногоо тариалахад зориулагдсан нэгдсэн усалгааны системийг бий болгож хөгжүүлнэ.
- 5.11. Ажлын байрны эрэлтийг бүрэн хангах зорилгоор хөдөлмөр эрхлэлтийн шинэлэг хэлбэр бий болгоход анхаарч ажиллана.
- 5.12. Малчдад нэн шаардлагатай байгаа мал тарилгын хашаа болон мал угаалгын ванныг үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлыг малын тоо толгойн албан татварын эх үүсвэрээр хэрэгжүүлнэ.
- 5.13. Мал амьтны өвчний гаралт, тархалтыг бууруулж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

- 5.14. Тариалангийн үйлдвэрлэлд тэг болон цомхотгосон, усалгааны хэмнэлттэй дэвшилтэт технологи нэвтрүүлж, байгальд ээлтэй бордооны хэрэглээг төлөвшүүлэн, хөрсний үржил шимийг хамгаалж, сайжруулна.
- 5.15. Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, доройтлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 5.16. Сумын нутаг дэвсгэрт үлийн цагаан оготны тархацын судалгааг явуулж, бэлчээрт хөнөөл учруулж буй царцаа, үлийн цагаан оготно гэх мэт мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.
- 5.17. Номуухаан хорооллын 240 га талбайн услалтын системийн ашиглалтыг 100%-д хүргэж, тус усан байгууламжийн үйл ажиллагааг хэвийн явуулахад анхаарч ажиллана.

### ЗУРГАА. ХҮНИЙ ХӨГЖИЛ, ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- 6.1. Сумын ЗДТГ-ын шинэ байрны барилгын зураг төслийг хийлгэж, улсын төсөвт суулгуулах ажлыг зохион байгуулна.
- 6.2. Төрийн албан хаагчид, багш, эмч нарын нийгмийн асуудлыг холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлэх, ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлсэнээр ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.
- 6.3. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд иргэдийг хамруулж, байнгын болон түр ажлын байраар хангах ажлыг эрчимжүүлнэ.
- 6.4. “Халамжаас-хөдөлмөрт” хөтөлбөрийн хүрээнд багийн иргэдийг бүрэн хамруулах, зуучлах үйлчилгээг хэрэгжүүлнэ.
- 6.5. Сумын хэмжээнд үндэсний өв уламжлал, сумын түүхийн талаарх судалгаа явуулж, “Уламжлалт нүүдлийн ахуй” соёлыг түгээн дэлгэрүүлэхэд эерэг хандлагатай иргэдийг төлөвшүүлэх.
- 6.6. “Бүх нийтийн соёлын боловсрол II” арга хэмжээний хүрээнд ажил үйлчилгээг тогтмолжуулна.
- 6.7. Сумын хэмжээнд нийтийн биеийн тамир, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг аж төрөх ёсны салшгүй хэсэг болгох, спорт, урлагийн салбарт амжилт гаргагчдыг хөхүүлэн дэмжиж ажиллана.
- 6.8. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зохих хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж ажиллана.
- 6.9. Ивэн 1 дүгээр баг, “Баавгайт”-ын ам дахь хүүхдийн хөдөлмөр амралтын зусланг засварлан сэргээж, ашиглалтад оруулна.
- 6.10. Сумын төвийн цэцэрлэгт хүрээлэн, багуудын хүүхдийн тоглоомын талбайг стандартын шаардлага хангасан биеийн тамир, бие бялдар хөгжүүлэх төхөөрөмж, хүүхдийн тоглоомоор баяжуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, бүрэн бүтэн байдлыг хангахын тулд камержуулах ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.
- 6.11. Төрийн албан хаагчийн 12 айлын орон сууцыг фасадлах, дулааны шугам, сантехникийн засварын ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.

Иргэдийнхээ хөгжих, тав тухтай, сэтгэл дүүрэн амьдрах, ажиллах, амрах орчныг бүрдүүлсэн хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй, эрүүл чийрэг, бүтээгч, оюунлаг иргэдтэй, амар тайван сум болно

Сэлэнгэ аймгийн Сант сумын МАН-ын Хорооноос 2024 оны орон нутгийн сонгуульд оролцохдоо дэвшүүлж баг, сум, орон нутгаа хөгжүүлэх энэхүү зорилтуудыг Та бид хамтран хэрэгжүүлж, ахмад үеийнхээ хөдөлмөрч, дайчин, шударга уламжлалыг хадгалж, хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхны төлөө Сант сайхан нутгаа **“ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ”**.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНТ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**